



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2010-08-25

Улаанбаатар хот

Дугаар 141

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх хэсгийг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. "Нийслэлийн ногоон бүсийн ашиглалт, хамгаалалтын журам"-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Г.МөнхбаярЛд үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн "Нийслэлийн ногоон бүсийн ашиглалтын журам" батлах тухай 1999 оны 57 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Т.БИЛЭГТ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. 1. Нийслэлийн ногоон бүсийн нутаг дэвсгэр дэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон байгалийн нөөц баялгийг ашиглах, эзэмших, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. 2. Энэхүү журмыг нийслэлийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн бүр дагаж мөрдөнө.

Хоёр. Нийслэлийн ногоон бүсэд хамрагдах нутаг дэвсгэр, түүний зориулалт

1. 1. Нийслэлийн ногоон бүсийн хилийн цэст Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 326 дугаар тогтоолоор батлагдсан ойн сан, усны ай сав, байгалийн ургамал бүхий газрууд багтана.

2. 2. Нийслэлийн ногоон бүс нь хотын агаарыг цэвэршүүлж, усны горимыг зохицуулах, иргэдийн ая тухтай амьдрах, зөв зохистой амрах зориулалттай байна.

3. 3. Нийслэлийн ногоон бүсийг байгалийн унаган төрх байдал, эрүүл ахуйн ач холбогдлыг нь хадгалах зорилгоор зуслан, амралт зугаалга, аялал жуулчлалын зориулалтаар хамгаалан ашиглах бодлого баримтална.

Гурав. Нийслэлийн ногоон бүсийн байгалийн нөөц баялгийн ашиглалт, хамгаалалтын талаар

1. 1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр нийслэлийн ногоон бүсийн ойд дор дурьдсан үйл ажиллагаа явуулж болно.

а. Ойн сангийн бүтэц, бүрэлдэхүүнийг сайжруулах зорилгоор ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээг жил бүр улсын болон нийслэлийн төсөвт тусган, эрх бүхий мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх;

б. Ойн сангийн өөрчлөлтийн бүртгэл хийж, хөнөөлт шавьж, өвчний судалгаа явуулж, түүнээс урьдчилан сэргийлж, устгал тэмцлийн ажлыг хийх;

в. Ойд түймрийн халз, шороон зурвас байгуулах ажлыг технологийн дагуу гүйцэтгэх;

г. Ойн тухай хуулийн 31.1-д заасны дагуу тухайн нутагт оршин суугч иргэн зөвхөн түлшний зориулалтаар унанги, гишүү, мөчрийг зохих төлбөр, хураамжийг төлж зөвшөөрөл авсны үндсэн дээр бэлтгэх;

д. Ой зохион байгуулалтыг 10 жилд нэг удаа 1 дүгээр зэрэглэлээр гүйцэтгэх ба зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх;

1. 2. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор хавар, намрын хуурайшилтын үе болох 3 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 10, 9 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ныг хүртэл ойн дагалт баялаг ашиглах, ойгоос түлээ бэлтгэх, аялал зугаалгаар явахад тавих хяналтыг чангатгаж, шаардлагатай тохиолдолд хориглох хүртэл арга хэмжээг авна.

2. 3. Байгаль орчны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хянах зорилгоор хотын авто техникийн шалган бүртгэх товчоодод шалгагч, байцаагчийг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас томилон ажиллуулна.

3. 4. Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу газрын хэвлийгээс барилгын түгээмэл тархацтай түүхий эд олборлохдоо зөвхөн тогтоогдсон карьеруудыг ашиглаж, нөхөн сэргээлтийг ашиглагч байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

Дөрөв. Нийслэлийн ногоон бүсэд газар ашиглуулах, эзэмшүүлэх талаар

4.1. Нийслэлийн ногоон бүсэд газар ашиглах, эзэмших зөвшөөрөл олгохдоо тухайн жилийн газар зохион байгуулалтын болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Байгаль орчны дүгнэлтийг үндэслэнэ.

4.2. Шинээр байгуулах болон одоо ажиллаж буй үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, газар эзэмших, ашиглах төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх бөгөөд энэхүү үнэлгээний хүрээнд төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тогтоож дүгнэлт гаргана.

4.3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг Нийслэлийн Байгаль хамгаалах газар хийх бөгөөд нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай төсөлд холбогдох тодорхойлолтыг хийж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар ерөнхий үнэлгээ хийлгүүлнэ.

## Хавсралт

4.4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, дүгнэлт болон нарийвчилсан үнэлгээ нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрээний хавсралт болж, гэрээтэй хамт дүгнэгдэнэ.

1. 5. Төвлөрсөн болон төвлөрсөн бус усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд хамрагдах газрыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 51/75 тоот хамтарсан тушаалаар батлагдсан £Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм<sup>а</sup>-д нийцүүлэн шийдвэрлэнэ.

2. 6. Мал аж ахуйг Нийслэлийн Засаг даргын 2002 оны 411 дүгээр захирамжаар батлагдсан £Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас мал аж ахуй эрхлэх журам<sup>а</sup> - д заасан бүс нутагт эрхэлнэ.

3. 7. Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал бүхий иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг үе шаттайгаар гүйцэтгэнэ.

Тав. Нийслэлийн Байгаль хамгаалах газрын эрх үүрэг

5.1. Байгалийн дагалт баялгийг зөвшөөрлийн дагуу төлбөр, хураамжийг төлсний үндсэн дээр технологийн дагуу ашиглуулна.

1. 2. Ойг сийрэгжүүлэх журмаар зохих зөвшөөрлийн дагуу хот тохижилтонд зориулж мод, бут, сөөгийг олгоно.

2. 3. Нийслэлийн ногоон бүсэд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар ан амьтан агнах, барих үйл ажиллагааг хориглоно.

3. 4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага худаг гаргах буюу усны эх үүсвэрийг ашиглахад зөвшөөрөл өгнө.

4. 5. Ногоон бүсэд аялал, зугаалга, биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоно.

5. 6. Байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, биелэлтийг дүгнэж мэдээлэх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж шийдвэрлүүлнэ.

6. 7. Нийслэлийн ногоон бүсийн ашиглалт, эзэмшилт, хамгаалалтанд хяналт тавьж илэрсэн зөрчлийг шуурхай арилгуулах ажлыг зохион байгуу

1. 8. Байгаль хамгаалах чиглэлээр ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагуудтай ажлаа уялдуулан зохицуулж хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

2. 9. Нийслэлийн ногоон бүсийн ашиглалт, эзэмшилт, хамгаалалтын байдалд жил бүр үнэлэлт дүгнэлт гаргаж цаашид нөхөн сэргээх, хамгаалах асуудлаар төсөв төлөвлөгөөнд тусгуулж хэрэгжүүлнэ.

3. 10. Нийслэлийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгальтай харьцах үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллана.

4. 11. Нийслэлийн Байгаль хамгаалах газрын Зуслангийн товчоо нь айл өрх, байгууллагуудаар орчных нь цэвэрлэгээг тогтмол хийлгүүлэх, тохижуулах, зүлэгжүүлэх, хайс хашааг нь засаж сэлбүүлэх, өнгө үзэмжийг нь сайжруулах, төрөөс үзүүлж буй үйлчилгээний үнэ хөлсийг цаг тухайд нь төлүүлж байх, үйлчилгээний доголдол гарсан тухай бүр хамтран ажиллах гэрээ байгуулсан байгууллагуудад шуурхай мэдээлж холбогдох арга хэмжээг авахуулж, зөрчлийг барагдуулна.

5. 12. Зусланд нийтийн бие засах газар, хог хаягдлын нэгдсэн цэг, автомашины нэгдсэн зогсоол байгуулах ажлыг мэргэжлийн байгууллагуудад тавьж шийдвэрлүүлнэ.

Зургаа. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын эрх үүрэг

1. 1. Нийслэлийн ногоон бүсэд байгаль орчны хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын биелэлтийг хангуулж, хяналт тавьж ажиллана.

2. 2. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай боловсронгуй болгож, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хууль тогтоомж, стандартыг сахиулж мөрдүүлэх, экологийн тэнцэл алдагдах, орчин бохирдож доройтохоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

3. 3. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангуулах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

4. 4. Зуслангийн айл өрхүүдийн орчны цэвэрлэгээ, бие засах газар, бохирын цооногийн ариутгал

## Хавсралт

цэвэрлэгээ, хог хаягдлыг ачих, тээвэрлэх ажилд хяналт тавьж, булаг, шандын уснаас шинжилгээ авч, ариутгаж халдваргүйжүүлэх талаар холбогдох байгууллагад үүрэг өгч, хэрэгжилтэнд нь хяналт тавина.

5. 5. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын бэлэн байдалд хяналт тавина.
6. 6. Ой, усны сан газарт хууль зөрчин газар эзэмшиж, ашиглаж байгаа зөрчилд шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулна.
7. 7. Гадаргын болон газар доорхи усны эх үүсвэрийн бохирдолтод хяналт тавина.

Долоо. Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын менежментийн хэлтсийн эрх үүрэг

1. 1. Зуслангуудад хогийг ил задгай хаяхаас хамгаалсан, ангилан ялгалт хийх боломжтой хогийн цэгийг байгуулах, эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавих ажлыг зохион байгуулна.
2. 2. Зуслангийн айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудаас гарч буй хог хаягдлын байдалд орчны эрүүл ахуй, байгаль орчны хяналт хариуцсан байгууллагатай хамтран байнгын хяналт тавьж ажиллана.
3. 3. Хур хог хаягдлыг цэвэрлэх, ангилан ялгах, дахин цэвэрлэх үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
4. 4. Ногоон бүсэд байрлах нийтийн бие засах газруудыг байгуулах ажлыг үе шаттай авч хэрэгжүүлнэ.

Найм. Дүүргүүдийн Засаг даргын эрх үүрэг

1. 1. Дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах асуудал хариуцсан ажилтны ажлын байрны тодорхойлолтод Нийслэлийн Байгаль хамгаалах газраас санал авч батална.
  2. 2. Ногоон бүсэд жилд хоёроос доошгүй удаа Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Байгаль хамгаалах газартай хамтарсан үзлэг шалгалтыг зохион байгуулж, арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
  3. 3. Ногоон бүсэд зуслангийн газар олгохдоо байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ дүгнэлтийг үндэслэн газар эзэмших, ашиглах гэрчилгээ олгоно.
  4. 4. Ойн санг эзэмших талаар иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг Нийслэлийн Байгаль хамгаалах газраас санал авсны үндсэн дээр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол гаргуулан дүүргийн Засаг дарга гэрээ байгуулж, гэрчилгээ олгоно.
  5. 5. Ногоон бүсэд байнга болон түр оршин суугч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас дүүргийн Хог хаягдал үйлчилгээний сан хог хаягдал гаргасны төлбөр цуглуулж, гэрээ байгуулан хогийг тээвэрлэж ачуулна.
  6. 6. Зуслангийн байшин барилгуудыг хаягжуулж дугаарлах, тохижилт, үйлчилгээ, өнгө үзэмжийг сайжруулах, хайс хашлагыг жигдрүүлэх зэрэг үйлчилгээг зохион байгуулна.
  7. 7. Зуслангийн хүн амын нягтрал, хэрэгцээ шаардлагыг судлан худалдаа, үйлчилгээг зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.
  8. 8. Дүүргийнхээ байгаль хамгаалагчдын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
  9. 9. Ой хээрийн түймрээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, гал түймрийн аюултай, хуурайшилттай үед морин эргүүл томилон ажиллуулж, зохих урамшууллыг олгоно.
  10. 10. Ойн түймэр гарсан үед түймэр унтраах ажлыг шуурхай зохион байгуулна.
  11. 11. Ногоон бүсэд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоох, албадан нүүлгэх ажлыг зохион байгуулна.
  12. 12. Зуслангийн байшин барилгыг хаягжуулах, тохижилт, цэвэрлэгээ хийх ажлыг иргэдийн оролцоотойгоор зохион байгуулна.
  13. 13. Зуслангийн чиглэлийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол байгуулна.
  14. 14. Ногоон бүсийн булаг шандыг хамгаалах, ойжуулах, нөхөн сэргээхэд жил бүр хөрөнгө төсөвлөнө.
- Ес. Нийслэл, дүүргийн Газрын албаны эрх үүрэг

## Хавсралт

1. 1. Зуслангийн газрын газар зохион байгуулалтын болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн газар эзэмших, ашиглах асуудлыг шийдвэрлэнэ.

2. 2. Зуслангийн газрын харилцааны маргаантай асуудлаар хандсан санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлүүлнэ.

3. 3. Нийслэлийн ногоон бүсэд газар эзэмших, ашиглах бүх шатанд газар эзэмшигч, ашиглагчдыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, дүгнэлтэнд бүрэн хамруулна. Арав. Бусад байгууллагын эрх үүрэг

10.1. Нийслэлийн Авто замын газар нь зуслангийн чиглэлийн зам, гүүрийн эвдрэлийг засч, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай газруудад тэмдэг, тэмдэглэгээг тавина.

1. 2. Нийтийн тээврийн газар нь Зуслангийн нийтийн тээврийн үйлчилгээний зохион байгуулалт, үйлчлэх автобусны цагийн хуваарь, хугацаа, зогсох зогсоол, эцсийн буудлуудын байршил байгуулах зэрэг ажлыг зохион байгуулна.

2. 3. "Цахилгаан түгээх сүлжээ" хувьцаат компани нь зуслангийн айл өрх, байгууллагуудыг цахилгаанаар хэвийн найдвартай хангах, эвдрэл саатал гарсан тохиолдолд шуурхай үйлчлэх ажлын хэсгийг дүүрэг бүрт зохион байгуулж, цахилгаан шугам сүлжээний өргөтгөл, шинэтгэлийн ажлыг жил бүрийн төсөл төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллана.

3. 4. Ус сувгийн удирдах газар нь зусланд ундны ус тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгслийг тогтоосон чиглэлд хүн амын нягтралыг харгалзан батлагдсан графикайн дагуу явуулж, ус хангамжийн хүрэлцээний талаар ирсэн санал хүсэлтийг барагдуулах диспетчерийг ажиллуулна.

4. 5. Нийслэлийн Эрүүл мэндийн газар нь хүн амд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх ажлын хүрээнд эмнэлэг, эмийн сангийн үйлчилгээг хариуцан ажиллана.

5. 6. Нийслэлийн Цагдаагийн газар нь зуслангийн айл өрхүүдийн амгалан тайван байдлыг хангах, гэмт хэрэг хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, зусланд цагдаагийн хэсэг, эргүүл ажиллуулна.

6. 7. Замын цагдаагийн газар нь "Замын хөдөлгөөний дүрэм-ийг зөрчсөн үйлдлийг таслан зогсоох арга хэмжээг авна. Цаг үеийн нөхцөл байдалд тохируулан шаардлагатай үед удирдамжийн дагуу нэгдсэн үзлэг шалгалт, арга хэмжээнд хамтран ажиллахаар оролцох, зуслангийн замд замын цагдааг томилон ажиллуулна.

7. 8. Нийслэлийн Онцгой байдлын газар нь ногоон бүсэд гал түймрийн аюулаас сэрэмжлэх, гал түймэр гарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авч ажиллахын зэрэгцээ гамшиг, ослын үед шуурхай албаны машин чөлөөтэй нэвтрэхэд зориулагдсан орц, гарцыг бий болгох ажлыг зохион байгуулна.

8. 9. Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс нь ногоон бүсэд худалдаа үйлчилгээний ажлыг зохион байгуулж, зөвхөн аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрлийг олгож үйл ажиллагаанд нь хяналт тавина.

Арван нэг. Нийслэлийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагын хүлээх үүрэг

11.1. Нийслэлийн ногоон бүсийн нутаг дэвсгэрт амьдарч буй иргэн бүр байгалийн нөөц баялгийг хамгаалах, түүний нөхөн сэргээх нөхцөлийг хангах, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүй байхад туслах, гарч буй зөрчлийг шуурхай мэдээлж, арилгуулна.

11.2. Нийслэлийн ногоон бүсийн иргэд нь хог тээврийн төлбөрөө цаг хугацаанд нь төлж, хөрс, ус бохирдуулахгүй байх, ил задгай хогийн цэг үүсгэхгүй байна.

11.1.3. Гал түймрийн аюултай үед галын эргүүл постонд оролцож, түймэр гарсан үед унтраах багаж хэрэгсэл бэлтгэх, шуурхай албаны автомашин орох, гарах зам гарцыг чөлөөлнө.

11.4. Ногоон бүсэд байнга оршин суугч иргэд нь зохих төлбөр, хураамжийг төлсний үндсэн дээр ойгоос түлээ бэлтгэх эрхийн бичгээр түлшний зориулалтаар зөвхөн байгаль хамгаалагчийн заасан газраас түлээ бэлтгэх бөгөөд түүнийг хот руу оруулахгүй байна.

11.5. Ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, аялал жуулчлалын баазууд нь жил бүр байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөтэй ажиллана.

11.6. Ногоон бүсэд амрах, аялал зугаалгаар явахдаа Нийслэлийн Байгаль хамгаалах газраас зөвшөөрөл авч, хог хаягдлаа төвлөрсөн хогийн цэгт хаяж, уг газраа байгаль хамгаалагчид хүлээлгэн өгнө.

11.7. Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь ойр орчныхоо хог хаягдлыг цэвэрлэх ажилд идэвхи

## Хавсралт

санаачлагатай оролцоно.

11.8.Нийслэлийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулдаг оршин суугч айл өрх, аж ахуйн нэгж байгууллага нь орчин тойрноо тохижуулж зүлэгжүүлэх, ойжуулах, хайс хашаагаа засаж сэлбэх, байшин барилгынхаа өнгө үзэмжийг сайжруулах ажлыг тогтмол хийнэ.

11.9.Нийслэлийн ногоон бүсэд худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зуслангийн товчоотой хамтран ажиллах гэрээ байгуулж гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.

11.10.Ногоон бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг чандлан мөрдөж, автомашины болон явган хүний орц, гарцыг чөлөөтэй байлгана.

Арван хоёр. Хориглох зүйл

12.1.Нийслэлийн ногоон бүсэд дор дурьдсан зүйлсийг хориглоно.

12.1.1.Нийслэлийн ногоон бүсэд бүх төрлийн үйлчилгээг холбогдох байгууллагуудын зөвшөөрөлгүй явуулах;

12.1.2.Мод, бут, сөөгийг огтлох, газрын хөрсийг эвдэх, шинэ зам гаргах, гол, горхи, булаг, шандын усыг бохирдуулах;

12.1.3.Ногоон бүсэд мал бүхий иргэдийг суурьшуулах, мал аж ахуй эрхлэх;

12.1.4.химийн хортой бодисыг хадгалах, булах, дарах;

12.1.5.Нийслэлийн ногоон бүсэд газрын хэвлийг дур мэдэн ашиглах, зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж барих;

12.1.6.Ногоон бүсээс хэрэглээний мод бэлтгэх;

12.1.7.Ногоон бүсэд байнга оршин суудаг айл өрхөд түлшний зориулалтаар түлээний эрхийн бичгээр олгосон модыг хот руу оруулах;

12.1.8.Амралт, зуслан бүхий амуудад газар хагалж ногоо тарих, боловсроогүй үр жимс түүх, газар шорооны ажил эрхлэх

Арван гурав. Хүлээлгэх хариуцлага

13.1.Энэхүү журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Арван дөрөв. Төлбөр хураамж

14.1.Энэхүү журамд хамаарах төлбөр, хураамжийн хэмжээг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.